



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 255

Улаанбаатар хот

**“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулах,  
зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг  
шинэчлэн батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 83 дугаар тогтоолоор баталсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.5.3 дахь хэсгийг хассугай.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 83 дугаар тогтоолоор баталсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.9, 5.10, 8.2 дахь хэсгүүдийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

1./ Дүрмийн 5.9 дэх заалт:

“5.9.Захирал нь дэргэдээ Газрын бүтцийн нэгжийн удирдлагаас бүрдсэн захирлын зөвлөлтэй байж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирал батална.”

2./ Дүрмийн 5.10 дахь заалт:

“5.10.Газрын захирлын түр эзгүйд байгууллагын өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах зорилгоор Захиргааны хэлтсийн дарга орлоно.”

3./ Дүрмийн 8.2 дахь заалт:

“8.2.Газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Захирал, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

3.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 165 (Нэг зуун жаран тав) байхаар тогтоосугай.

4.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр, албан тушаалтын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 535 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

• 132002499

6.Дүрэмд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд зохих журмын дагуу бүртгүүлэхийг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Б.Ичинхорлоо)-д даалгасугай.

7.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ